



ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 12 сарын 17 өдөр

Дугаар 41665

Хэрлэн сум

Стратеги төлөвлөгөөний төсөл боловсруулах ажлын хэсэг томилох тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, 60 дугаар зүйлийн 60.1.1 дэх заалт, Монгол Улсын Их Хурлын 2021 оны 106 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий Сайдын 2024 оны 02 дугаар албан даалгаврыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1."Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Шинэ сэргэлтийн бодлогын хэрэгжилтийг эрчимжүүлэх чиглэлээр гарсан Монгол Улсын Ерөнхий Сайдын 2024 оны 10 дугаар сарын 30-ны 02 дугаар албан даалгаврыг хэрэгжүүлэх хүрээнд (1) хиймэл оюун ухаан, өндөр технологийн шилжилт, (2) ногоон хөгжлийн шилжилт, (3) хөдөлмөрийн зах зээл, хүний нөөцийн ур чадварын шилжилт хийх чиглэлээр хамаарах салбар болон бүс, орон нутгийн хэмжээнд шаардлагатай хэлэлцүүлэг зохион байгуулж, стратеги төлөвлөгөөний төслийг боловсруулах ажлын хэсгийг нэг, хоёр, гуравдугаар хавсралт дахь бүрэлдэхүүнээр томилсугай.

2.Салбар чиглэл тус бүрээр хэлэлцүүлэг зохион байгуулж, стратеги төлөвлөгөөний төслийг боловсруулж, заасан хугацаанд Эдийн засаг хөгжлийн яаманд хүргүүлэхийг ажлын хэсгийн ахлагч нарт, захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Ж.Гантулга)-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Д.АЮУРБУНЬ



Аймгийн Засаг даргын 2024 оны
12 дугаар сарын 12 -ний өдрийн
11/665 дугаар захирамжийн нэгдүгээр хавсралт

(1) ХИЙМЭЛ ОЮУН УХААН, ӨНДӨР
ТЕХНОЛОГИЙН ШИЛЖИЛТ ЧИГЛЭЛЭЭР

Ажлын хэсгийн ахлагч	Ч.Баярцолмон	Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга
Нарийн бичиг	Т.Жанчив	Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн мэргэжилтэн, Эрчим хүчний хяналтын улсын ахлах байцаагч
Гишүүд	Ж.Энхбат	Аймгийн Засаг даргын Тамгын газар Компьютерийн технологи, програм хангамж хариуцсан мэргэжилтэн
	О.Од-Эрдэнэ	Хэнтий аймгийн Мэдээлэл холбооны сүлжээ ХХК-ийн газрын дарга
	Х.Мөнхжаргал	Монголын цахилгаан холбоо ХК-ийн Хэнтий аймгийн Холбооны газрын дарга
	Ц.Батжаргал	Цахим хэлтсийн дарга



Аймгийн Засаг даргын 2024 оны
дугаар сарын 12-ний өдрийн
дугаар захирамжийн хоёрдугаар хавсралт

(2) Ногоон хөгжлийн шилжилт

Ажлын хэсгийн ахлагч:	Э.Мөнх-Эрдэнэ	Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга
Нарийн Бичиг:	Б.Мөнхжаргал	Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн ахлах мэргэжилтэн
Гишүүд:	Б.Амгаланбат	Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга
	Б.Хэрлэнчимэг	Ус цаг уур, орчны шинжилгээний төвийн дарга
	Б.Нандинцэцэг	Хэрлэн голын сав газрын захиргааны дарга

Аймгийн Засаг даргын 2024 оны
дугаар сарын 12-ний өдрийн
А/168 дугаар захирамжийн туравдугаар хавсралт

(3) Хөдөлмөрийн зах зээл,
хүний нөөцийн ур чадварын шилжилт

Ажлын хэсгийг
ахлагч:

Н.Зоригтбаатар

Нийгмийн бодлогын хэлтсийн дарга

Нарийн
Бичиг:

Г.Пүрэвбаатар

Хүн, ам зүйн нийгмийн хамгаалал,
хөдөлмөр эрхлэлт, гэр бүл, хүүхэд
залуучуудын бодлого хариуцсан
мэргэжилтэн

Гишүүд:

С.Мөнхцэцэг

Боловсрол, шинжлэх ухааны газрын
дарга

Э.Хонгорзул

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний
газрын дарга

Б.Болд-Эрдэнэ

Политехник коллежийн захирал